



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин,
аюулгүй байдал, орон нутаг

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Зорилго.....	4
1.2 Хэрэглээ	4
1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа.....	4
1.4 Эрх мэдэл болон удирдлага.....	4
2. ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ.....	5
2.2 Удирдлагын бусад төлөвлөгөөтэй давхцах нь	5
3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГУУД	5
3.1 Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн гол үүрэг хариуцлага.....	5
4. ТӨСЛИЙН СТАНДАРТУУД	7
4.1 Монгол улсын холбогдох үндэсний стандартууд	7
4.2 БОНБНУ-нд заагдсан шаардлагууд	7
4.3 МУ-ын ЗГ болон төрийн байгууллагуудын бусад үүрэг даалгавар болон шаардлагууд	8
4.4 Зээлдүүлэгчдийн стандарт болон удирдамжууд.....	8
4.5 Рио Тинтогийн стандартууд	8
4.6 Оюу Толгойн зүгээс даган мөрдөх үүрэг бүхий бусад аж үйлдвэрийн салбарын зааварчилгаа	9
4.7 Төсөлд хэрэглэж буй стандартуудын тойм.....	9
5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД	11
5.1 Дуу шуугиан, чичиргээнд хандах ерөнхий хандлага	11
5.2 Хэрэгжилт.....	12
6. ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ	15
6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт болон өөрчлөлт	15
7. МОНИТОРИНГ	15
7.1 Мониторингийн шаардлагуудын тойм.....	15
7.2 Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд.....	15
7.2.1 Мониторингийн гол үйл ажиллагаанууд	16
8. СУРГАЛТ	18
8.1 Тойм	18
8.2 Танилцуулах зааварчилгаа	18

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01

Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-PLN-0001-М

Хувилбар:
2.0

8.3 Ажлын байран дахь сургалт	18
8.4 Бусад сургалтын хэрэгцээ шаардлага	18
9. АУДИТ БОЛОН ТАЙЛАН	18
9.1 Дотоод аудит.....	18
9.2 Гадаад аудит.....	19
9.3 Гүйцэтгэлийн тайлан	19
10. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ.....	19
ХҮСНЭГТҮҮД	
Хүснэгт 1 Гол хариуцагчид, тэдгээрийн үүрэг хариуцлага.....	7
Хүснэгт 2: Дуу шуугиан, чичиргээний стандартууд	12
Хүснэгт 2: Гадны дуу шуугиан, чичиргээнд нөлөөлөх бүх хүчин зүйлс	14
Хүснэгт 3: Удирдлагын гол хяналтууд	16
Хүснэгт 4: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд– Дуу шуугиан, чичиргээ	18
Хүснэгт 5: Мониторингийн арга хэмжээ– Дуу шуугиан, чичиргээ	20

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөөХүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-PLN-0001-МХувилбар:
2.0**1. ТАНИЛЦУУЛГА****1.1 Зорилго**

Удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын холбогдох нэгжүүдийн уялдаа холбоог харуулах;
- ажлын байрны үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн холбогдох стандартууд, удирдамжуудыг тоймлон гаргах;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн үүрэг даалгавар, үйл ажиллагааны журам, удирдамжийг тодорхойлж, энэ төлөвлөгөөнд тусгагдсан Оюутолгой компанийн Байгаль орчны бодлогын шаардлагуудыг тодруулах;
- Гүйцэтгэлийн Гол Үзүүлэлт (ГҮҮ)-ийг багтаасан мониторингийн болон тайлагналтын журмыг тодорхойлох;
- Сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ба
- Холбогдох материал, мэдээллийн эх сурвалжууд, лавлагааг тодорхойлох.

1.2 Хэрэглээ

Энэ удирдлагын төлөвлөгөөнд заасан шаардлагыг Оюутолгой компанийн бүх үйл ажиллагаанд, тэр дундаа гэрээт ажилтнуудын үйл ажиллагаанд мөрдөнө.

1.3 Хэрэгжүүлж эхлэх хугацаа

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

1.4 Эрх мэдэл болон удирдлага

Оюутолгой Удирдах хороо нь энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр баталсан.

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдал, орон нутгийн хэлтсийн ерөнхий менежер энэ удирдлагын төлөвлөгөөг хариуцна. Төслийн бүтэц, дүрэм журамд орсон өөрчлөлтийг тусгахаар илүү ойр давтамжтайгаар хянан шинэчлэх шаардлагатай болоогүй л бол тус Удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам хянаж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт, шинээр мэдээлэл оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлно. Энэ удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг энэ албан тушаалтанд тавих ба тухайн саналыг зохих байдлаар хянан үзсэний гол дээр өөрчлөлт хийх эсэхийг шийдвэрлэнэ.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөөХүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-ПЛН-0001-МХувилбар:
2.0**2. ХАМРАХ ХҮРЭЭ****2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ**

Энэ удирдлагын төлөвлөгөө нь уурхайн талбайгаас гадагш байрлах захиргаа/компанийн оффисыг хамруулаад Оюутолгой төслийн бүх үйл ажиллагаанд мөрдөгдөж хэрэгжинэ. Тус төлөвлөгөөнд уурхайн олборлолт, баяжуулалт, бараа материал ачиж/буулгах дэд бүтэц, уурхайн талбайд болон талбайн гаднах тээвэр зэрэг хүмүүс, орон нутгийн иргэд болон хүрээлэн буй орчинд их хэмжээгээр нөлөөлж болох хайгуул болон ашиглалтын үеийн үйл ажиллагаанаас үүдэн гарч буй дуу шуугиан, чичиргээг тусгасан. Оюутолгойн түр сууринд амьдарч буй хүмүүсийг орон нутгийн иргэдтэй ижил тооцдог. Ажлын байрны дуу шуугиан, чичиргээ нь энэхүү удирдлагын төлөвлөгөөнд тусгагдаагүй ч мониторинг хэрхэн гүйцэтгэхийг зааварчилсан журам бүхий мониторингийн төлөвлөгөөг агуулсан Ажлын байрны эрүүл ахуйн хяналтын хүрээнд зохицуулна. Нэмэлт үйл ажиллагаа (жишээ нь эрчим хүч үйлдвэрлэх) эсвэл уурхайн талбайн гаднах тээвэрлэлтийн (жишээ нь замын хөдөлгөөн, авто тээвэр гэх мэт) үйл ажиллагаа нь Оюутолгой болон Оюутолгойн үйл ажиллагаатай холбоотой тохиолдолд энэхүү удирдлагын төлөвлөгөөнд хамрагдана.

2.2 Удирдлагын бусад төлөвлөгөөтэй давхцах нь

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Оюутолгой төслийн боловсруулсан Ашиглалтын шатны удирдлагын цогц төлөвлөгөөний нэг хэсэг бөгөөд энэ талаар Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөө (БОНМТ)-нд тусгасан болно(лав: ОТ-10-ПЛН-0003).

Тус удирдлагын төлөвлөгөө нь хэд хэдэн удирдлагын төлөвлөгөөнүүдтэй зарим талаар давхцдаг ба эдгээрт:

- Тээврийн удирдлагын төлөвлөгөө (лав. ОТ-10-С3-ПЛН-0001), ялангуяа уурхайн талбайгаас гадна зорчиж буй тээврийн хэрэгслээс үүдэх дуу шуугиантэй холбоотойгоор;
- Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө (лав. ОТ-10-ПЛН-0002), ялангуяа археологи, палеонтологийн олдвор бүхий газруудын ойролцоо чичиргээ үүсгэх, угсаатны зүйн холбогдолтой газруудын ойролцоо дуу шуугиан үүсгэхтэй холбоотойгоор;
- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө (лав. ОТ-10-Е9-ПЛН-1001), ялангуяа дуу шуугианний түвшин болон уурхайн лицензит талбайгаас гадагш буй зэрлэг амьтдыг үргээхтэй холбоотой;
- Газар хөндөх зөвшөөрөл авах журам (ОТ-10-Е9-PRC-0003-Е), нэн ялангуяа гарч болзошгүй дуу шуугианы зөрчлийг холбогдох орон нутгийн иргэдэд мэдэгдэхтэй холбоотой.
- Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо (ОТ-07-ПЛН-0001-Е) Оюу толгойн ЭМААБО-ны удирдлагуудын хэрэгжилттэй холбоотой.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0

3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГУУД

3.1 Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн гол үүрэг хариуцлага

Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол албан тушаалтнууд болон тэдний үүрэг хариуцлагыг доорх байдлаар тоймлон харуулав.

Хүснэгт 1 Гол хариуцагчид, тэдгээрийн үүрэг хариуцлага

Үүрэг	Хариуцах үүрэг
ЭМААБОАБОН хариуцсан ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> Дуу шуугиан, чичиргээний мониторинг хийх, нөлөөлөл бууруулах, судалгаа болон хөгжлийн үйл ажиллагаа явуулахад шаардлагатай, хангалттай нөөц эх үүсвэр буйг баталгаажуулах.
Байгаль орчин ба биологийн төрөл зүйлийн менежер	<ul style="list-style-type: none"> Жил бүрийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ерөнхийлөн хариуцах. Дуушуугиан, чичиргээ зэрэг тухайн жилийн байгаль орчны гүйцэтгэлийг харуулсан байгаль орчны жилийн тайланг боловсруулах. Зохих нөөц бололцоогоор хангах. Энэхүү удирдлагын төлөвлөгөөг зөрчсөн/үл мөрдсөн тохиолдлыг (үүнд холбогдох хяналт болон стандартыг зөрчсөн тохиолдолд хамаарна) удирдлагын түвшинд хэлэлцэж, үр дүнтэй шийдэлд хүрэх.
ЭМААБОАБОН-ийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах баг	<ul style="list-style-type: none"> Дуу шуугиан, чичиргээтэй холбоотой МУ-ын хууль тогтоомжинд орсон нэмэлт өөрчлөлтийг хянаж, мэдээлэх
Байгаль орчны мониторингийн баг	<ul style="list-style-type: none"> Жил бүрийн Байгаль орчны мониторингийн төлөвлөгөөнд дуу шуугиан, чичиргээг тусгаж боловсруулах, дуу шуугиан, чичиргээний хяналт шинжилгээний үр дүн болон цаашдын хандлагын талаарх мэдээллийг холбогдох гүйцэтгэгч/гэрээт ажилтан, ЭМААБОАБОН-ийн удирдлагад мэдээлэх. Байгаль орчны жилийн тайлангийн дуу шуугиан, чичиргээтэй холбоотой бүлгийг боловсруулж, судалгаа, мониторинг болон нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг тодорхой тусгаж Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яаманд хүргүүлэх. Энэхүү удирдлагын төлөвлөгөөний Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтийг тогтмол хянаж, холбогдох оролцогч талуудад шинэчилсэн мэдээлэл түгээх, Дуу шуугиан, чичиргээтэй холбоотой сэдвүүдээр орон нутгийн, сумын иргэдийн төлөөлөл, малчидтай байнга уулзалт хийж, холбогдох уулзалтуудад оролцож байх.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0
Ашиглалтын хэлтсийн менежерүүд	<ul style="list-style-type: none"> Холбогдох удирдлагын хяналтнь энэхүү удирдлагын төлөвлөгөө болон зохих журмуудын дагуу явагдаж буй эсэхийг баталгаажуулах. Хэлтсийн ажилтнуудыг дуу шуугиан, чичиргээний удирдлагын хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бүрэн сургасан байх Гарсан зөрчил, хэрэг явдлыг магадлан шинжлэх үйл ажиллагаа явагдаж, тайлагнаж байгаа эсэхийг баталгаажуулах. Агаарын чанарын талаарх байгаль орчны мэдэгдэл эсхүл тайлангийн дагуу зохих засч залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх 	
Ажлын байрны ахлах ажилтан/ахлах мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> Холбогдох үйл ажиллагаа нь энэхүү удирдлагын төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэд хяналт тавьж, ажлын байрны үзлэг хийх Дуу шуугиан, чичиргээтэй холбоотой мэдээллийг бүртгэж, тайлагнах. 	
Бүх ажилчид, гэрээт ажилчид	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай бус дуу шуугиан, чичиргээ үүсгэж буй аливаа үйл ажиллагааг тайлагнан мэдээлэх. Шаардлагагүйгээр дуу шуугиан, чичиргээ үүсгэх аливаа үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх. 	
Хангамжийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> Худалдан авах ажиллагааны явцад тоног төхөөрөмж, машин механизмийн дуу шуугиан, чичиргээнд тавих шалгуур үзүүлэлтийг авч үзэх, ОТ-н нисэх буудалд ашигладаг бүх агаарын хөлгийг МУ-ын эрх бүхий байгууллагаар баталгаажуулж, СИСА-ийн хавсралттай нийцүүлэх Үйлчилгээний гэрээнд үйлчилгээ үзүүлэх явцад дуу шуугиан, чичиргээний хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагыг тусгах. 	
Сургалтын хэлтэс	<ul style="list-style-type: none"> Дуу шуугиан, чичиргээ үүсгэх үйл ажиллагааны талаар мэдлэг олгох сургалтуудыг хийх. 	
Дэд бүтцийн хэлтэс	<ul style="list-style-type: none"> Дуу шуугиан ихээр ялгаруулагч тоног төхөөрөмжийг нөлөөлөлд өртөгчдөөс хол байршуулах; 	
Ил уурхайн хэлтэс	<ul style="list-style-type: none"> Тэсэлгээний ажлаас үүсэх чичиргээг багасгах. 	
Нийгмийн харилцааны хэлтэс	<ul style="list-style-type: none"> Дуу шуугиан, чичиргээтэй холбоотой орон нутгийн иргэдээс тавьсан асуудлыг хянаж зохицуулах. Дуу шуугиан, чичиргээтэй холбоотой санал гомдлыг хянаж, мэдээлж зохих удирдлагын арга хэмжээ авах. 	
Гэрээт байгууллагуудын хамтын ажиллагааны хэлтэс	<ul style="list-style-type: none"> Гэрээтүүдийн ЭМААБО-ны удирдлагын төлөвлөгөөнд тусгагдсан дуу шуугиан болон доргио чичиргээний хяналтын арга хэмжээнүүдийн биелэлт, хэрэгжилт дэх гүйцэтгэлийг сар бүр үнэлэх (Сар бүрийн Гэрээт байгууллагуудын үнэлгээний хурал) 	

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөөХүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-PLN-0001-МХувилбар:
2.0**4. ТӨСЛИЙН СТАНДАРТУУД**

Төслийн бүхий л үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг (төслийн стандартууд) дагаж мөрдөнө. Төслийн стандартуудад:

- Монгол улсын холбогдох үндэсний стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-ний шаардлага;
- Монгол улсын Засгийн газар, түүний хэрэгжүүлэгч агентлагуудын шаардлага болон үүрэг даалгаварууд;
- Зээлдүүлэгчийн холбогдох стандарт, удирдамж;
- Рио Тинто компанийн холбогдох стандартууд;
- Оюутолгой компанийн мөрдөх ёстой аж үйлдвэрийн салбарын бусад удирдамжууд орно.

4.1 Монгол улсын холбогдох үндэсний стандартууд

Дуу шуугиан, чичиргээтэй холбоотойгоор хэрэгжих Монгол улсын гол байгаль орчны чанарын стандартуудад нь:

- MNS 4585:2007 Монгол улсын Агаарын чанарын үндэсний стандарт– дуу шуугианний зөвшөөрөгдөх түвшин.
- MNS 17.5.1.21:1992 Авто тээврийн хэрэгслийн дуу шуугиан. Дуу шуугианний хүлцэх түвшин, хэмжих арга
- Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн журам орно – Оюутолгойн уурхайн лицензийн талбайд тэсэлгээний үйл ажиллагааг явуулахдаа энэхүү журманд заагдсан шаардлагуудыг мөрдөх ёстой.

4.2 БОНБНҮ-нд заагдсан шаардлагууд

Хэд хэдэн БОНБНҮ-нүүдийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний төлөвлөгөөг хянан үзэж, холбогдох шаардлагуудыг Хүснэгт 2. Дуу шуугиан болон чичиргээний Стандарт ба Хүснэгт 4. Дуу шуугиан болон чичиргээний Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлтүүдийг тусган оруулсан.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөөХүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-ПЛН-0001-МХувилбар:
2.0**4.3 МУ-ын ЗГ болон төрийн байгууллагуудын бусад үүрэг даалгавар болон шаардлагууд**

Монгол улсын Засгийн газрын агентлагуудаас Оюу толгой төслийг тэсэлгээний зөвшөөрөл олгодог дотоод зөвшөөрлийн журамтай байхыг шаарддаг. Зөвшөөрөл нь олгогдохдоо Уулын ахлах инженер хянаж, гарын үсгээ зурж, баталгаажуулдаг байх ба тайлбайн ахлах мэргэжилтэнд тухайн тэсэлгээг гүйцэтгүүлэхээр илгээгддэг байна. Энэ зөвшөөрлийн хуудсанд тухайн хийх гэж байгаа тэсэлгээний загвар, хамрах талбай, байршил зэрэг нарийвчилсан мэдээллийг оруулж өгсөн байна.

4.4 Зээлдүүлэгчдийн стандарт болон удирдамжууд

Оюутолгойн мөрдөн хэрэгжүүлэх стандартууд нь Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК)-ийн стандартууд, Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны стандартууд байна. Үүнд:

- ОУСК-ийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандартууд (2006 он) (ялангуяа ГС1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ болон удирдлагын системүүд, ба ГС3 Бохирдлоос сэргийлэх болон бууруулах);
- ОУСК-ийн Байгаль орчин, аюулгүй ажиллагааны ерөнхий удирдамж (2007 оны 4 дүгээр сар); ба
- ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлагууд (2008 он) (ялангуяа ГШ1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон удирдлага).

ОУСК-ийн ГС3 нь “бохирдол” хэмээх утгаар дуу шуугиан болон чичиргээг давхар илэрхийлдэг бол *ОУСК-ийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны зааварчилгаанд* (2007 он) суурин эх үүсвэрээс үүдсэн дуу шуугианг хянах тэргүүлэх арга зүй нь тухайн эх үүсвэрээс үүсэж буй дуу шуугианг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан Олон нийтэд нөлөөлөх дуу шуугианний зааварчилгаанд (1999 он) заагдсаныг баримтлана хэмээн дурдсан байдаг. ОУСК нь өөрийн 2007 оны Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ерөнхий зааварчилгаанд мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зааварчилгааг иш татан дурдсан байдаг.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 3 нь төслүүдийг төлөвлөхдөө ЕХ-ны гаргасан байгаль орчны шаардлагуудын дагуу боловсруулахыг шаарддаг. ЕХ-ны Дуу шуугианний зааварчилгаа (2000/14/ЕС) нь орчны дуу шуугианний үнэлгээ болон удирдлагын ерөнхий суурь бүтцийг бий болгосон ч орчны дуу шуугианний хязгаарыг тогтоогоогүй, харин үүнийг тогтоох үүргийг өөрийн гишүүн орнуудад ноогдуулдаг. Иймд манай төслийн хувьд Монгол улсын болон олон улсын дуу шуугианний стандартуудыг даган мөрдөхөөр сонгон авсан ба эдгээрийг *Бүлэг 4.7-д* дурдсан.

4.5 Рио Тинтогийн стандартууд

Үүнийг Рио Тинтогийн *В3 – Гар ажиллагаа болон чичиргээний* (2015) стандарттай хамтад нь хэрэглэх ба тус стандарт нь ажлын байрны дуу шуугиан, чичиргээнээс үүсэх нөлөөллийг тодорхойлж өгдөг.

Бусад холбогдох Рио Тинтогийн баримт бичгүүдэд:

- E12 – Агаарын чанарыг хамгаалах стандарт;
- E14 – Газар хөндөхөд тавих хяналт, нөхөн сэргээлтийн стандарт;

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөөХүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-ПЛН-0001-МХувилбар:
2.0**4.6 Оюу Толгойн зүгээс даган мөрдөх үүрэг бүхий бусад аж үйлдвэрийн салбарын зааварчилгаа*****Нисэх буудлын дуу шуугиан (Олон улсын иргэний агаарын тээврийн конвенц)***

Олон улсын иргэний агаарын тээврийн 1944 оны конвенцын Хавсралт 16 нь агаарын хөлгийн дуу шуугианнээс хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг зохицуулдаг. Тус Хавсралт 16-г 1971 онд баталсан бөгөөд энэ нь агаарын хөлгийн дуу шуугиан; хүний агаарын хөлгийн дуу шуугианг хүлцэх хэмжээ; агаарын хөлгийн дуу шуугианний гэрчилгээжүүлэлт; агаарын хөлгийн дуу шуугианг бууруулах үйл явцыг бий болгох шалгуурууд; газар ашиглалтын хяналт; хөөрөх үеийн дуу шуугианг бууруулах журам зэргийг багтаасан. Оюутолгойн нисэх буудлуудад ашиглах нисэх онгоцууд нь Монгол улсын эрх бүхий байгууллагын гэрчилгээтэй байна. Монгол улс нь Иргэний нисэхийн олон улсын байгууллагын гишүүн орон юм. Оюутолгойн үйл ажиллагаанд ашиглагдаж буй агаарын хөлгөөс үүсэх дуу шуугианнээс үзүүлэх нөлөөллийг Иргэний нисэхийн олон улсын байгууллагын конвенцын хавсралтад заасны дагуу хязгаарлана.

Тэсэлгээний ажлаас үүсэх чичиргээ

Чичиргээтэй холбазрын чичиргээний оотой Монгол улсын ямар нэгэн стандарт байхгүй. Төсөл нь тэсэлгээний ажлын хувьд доорх зааварчилгааг даган мөрдөхөөр болоод байна: Австрали, Шинэ Зеландын Байгаль орчны зөвлөл, Тэсэлгээнээс үүдэх даралт болон хөрсний чичиргээнээс үүсэх асуудлыг бууруулах зааварчилгааны техникийн үндэслэл, 1990 он. Энэ баримт бичиг нь доорх шалгууруудыг чухалчлан авч үздэг. Үүнд:

- Тэсэлгээнээс үүсэх агаарын даралтын хязгаар – санал болгож байгаа зөвшөөрөгдөх хязгаар нь 115дБ (Линий дээд үзүүлэлт);
- Газрын чичиргээний дээд үзүүлэлтийн хурд - санал болгож байгаа зөвшөөрөгдөх хязгаар нь 5мм/с (дээд үзүүлэлтийн хурд (ППВ));
- Тэсэлгээний хугацаа – санал болгож байгаа хориг бол Даваа-Бямба гараигийн өглөөний 9:00-оройны 5:00 хүртэл болон
- Тэсэлгээний давтамж – ерөнхийдөө хоногт 1-ээс илүү хийж болохгүй.

Тэсэлгээний хугацаа, давтамжин дээр тавьдаг хориг нь тэсэлгээний нөлөөлөлд өртөхөөргүй талбай болон гүний уурхайн гол үйл ажиллагаанд хамаарахгүй болно.

4.7 Төсөлд хэрэглэж буй стандартуудын тойм

Дуу шуугиан, чичиргээний хяналттай холбоотойгоор сонгон хэрэгжүүлэх стандартуудын харьцуулалтыг доор буй *Хүснэгт 2* дээр, Оюутолгой төслийн хүрээнд ашиглах стандартуудын (Төслийн стандартууд) хамтаар харуулсан.

Оюутолгой нь үндэсний стандартууд, аолбогдох Зээлүүлэгчдийн стандартууд болон Рио Тинтогийн стандартуудаас хамгийн хатуу чанга стандартуудыг сонгон авч төслийн стандартууд болгон хэрэгжүүлнэ.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01

Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-ПЛН-0001-М

Хувилбар:
2.0

Хүснэгт 2: Дуу шуугиан, чичиргээний стандартууд

Бохирд уу лагч/Эх үүсвэр	Нөлөөлөлд өртөгч	Стандартууд ² (dB(A)Leq 1 цаг) (өөрөөр дурдаагүй бол)				Тайлбар
		ОУ СК ₁	ДЭМБ	Монгол улс	Төслийн (хамгийн чанга, хатуу)	
Дуу шуугиан	Талбайн хилийн хашаа	Ү/Х	Ү/Х	Ү/Х	75 дБ(А)	Оюутолгой нь уурхайн лицензит талбайн хилийн хашаанд хэвийн үйл ажиллагааны үеэр дуу шуугианний хязгаар 75 дБ(А)-аас хэтрэхгүй байхаар тогтоосон.
Дуу шуугиан (Уурхайн талбайн гаднах нөлөөлөл д өртөгчийн хувьд)	Үйлдвэрлэлийн/ Арилжааны (өдөр болон шөнийн цагаар)	70	-	60	60 дБ (А)	
	Оршин суух орон байр орчимд (өдрийн цагаар)	55	55	60	55 дБ (А)	Монгол улсын стандартаар өдрийн цагаар орчны дуу шуугиан 60 дБ(А)-аас хэтрэхгүй байх шаардлага тавигддаг. Энэхүү шаардлага нь ажилчдын амьдрах байрны хэсэгт хамаарна.
	Оршин суух орон байр орчимд (шөнийн цагаар)	45	45	45	45 дБ (А)	Монгол улсын стандартаар шөнийн цагаар орчны дуу шуугиан 45 дБ(А)-аас хэтрэхгүй байх шаардлага тавигддаг. Энэхүү шаардлага нь ажилчдын амьдрах байрны хэсэгт хамаарна.
Дуу шуугиан (Нисэх буудал)	Оршин суух орон байр орчимд (өдрийн цагаар)	-	-	-	65 дБ	Иргэний нисэхийн ерөнхий газар “ихээхэн хэмжээний дуу шуугианний нөлөөлөл” хэмээх тодорхойлолтод дуу шуугианний хэмжээ DNL 65 дБ буюу түүнээс дээш хэмжээтэй газрыг заадаг.
Чичиргээ	Ажиллах хүчний бус (тэсэлгээтэй холбоотой чичиргээ)			Тодорхойлоогүй	Тайлбарыг үзнэ үү	МУ-д чичиргээтэй холбоотой стандарт байхгүй. БОНБНУ болон бусад холбогдох стандартад хэмжилт хийх давтамжид тавих ямар нэгэн шаардлага байхгүй. Одоогийн байдлаар зохих хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдол гараагүй байна. Энэ нь нийт тэсэлгээний 5 хувиас хэтрэхгүй байхаар тооцоолох шаардлагагүй гэсэн үг. Тэсэлгээний талаар нэмэлт

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01

Бичиг баримтын дугаар:
ОТ-10-Е00-PLN-0001-М

Хувилбар:
2.0

Бохирдуу лагч/Эх үүсвэр	Нөлөөлөлд өртөгч	Стандартууд ² (dB(A)Leq 1 цаг) (өөрөөр дурдаагүй бол)				Тайлбар
		ОУ СК ₁	ДЭМБ	Монгол улс	Төслийн (хамгийн чанга, хатуу)	
						мэдээлэл шаардлагагүй.
Чичиргээ	Ажиллах хүчний бус (тэсэлгээнэ эс бусад эх үүсвэрийн чичиргээ)					Британийн стандарт 6472 – Иргэд оршин сууж буй газарт өдрийн цагаар тэсэлгээнээс үүсэх тоосонцорын хурдын хэмжээ нь 1.12 мм/сек хэмжээнээс хэтрэхгүй бол болно гэж үздэг. Дугаар. NV6 – Хэрэгжих стандартууд, Британийн стандартуудын бодлого, зааварчилгаа 5228 – Барилга болон ил талбайн дуу шуугианний хяналт

Тэмдэглэл:

¹ ОУСК нь уурхайн талбайн гадна буй хамгийн ойрхон нөлөөлөлд өртөгчид дуу шуугианний гадаргын түвшний хамгийн дээд хэмжээ нь 3 дБ-аас хэтрэхгүй байхыг шаарддаг.

² ЕХ-оос гаргасан дуу шуугианний удирдамжинд босго стандартыг тоон үзүүлэлтээр илэрхийлээгүй байдаг.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД

5.1 Дуу шуугиан, чичиргээнд хандах ерөнхий хандлага

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний ерөнхий зорилго нь дуу шуугиан, чичиргээнээс хүрээлэн буй орчин, ард иргэдэд үзүүлэх нөлөөллийг бууруулахад оршино. Үүний хүрээнд ургамал, амьтны аймаг, соёлын өвийн эд зүйлс болон хүрээлэн буй газар нутгийг хамруулж үздэг. Дуу шуугиан, чичиргээнд хийх хяналтыг дуу шуугиан, чичиргээний эх үүсвэрийг тогтоох, үнэлэх, эх үүсвэрүүдийг үүсэх нөлөөллийн хэмжээгээр нь эрэмбэлэх, зохистой хяналтыг төлөвлөх болон хэрэгжүүлэх арга хэмжээг авах замаар хэрэгжүүлдэг.

Хүснэгт 3. Гадны дуу шуугиан, чичиргээнд нөлөөлөх бүх хүчин зүйлс

#	Гол хүчин зүйлс болон үйл ажиллагаа	Байршил	Нөлөө
A	Уурхайн лицензийн талбайд		
1	Ил уурхай, хайрганы карьер, газар шорооны ажлын тэсэлгээ, өрөмдлөгтэй холбоотой үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Тэсэлгээ Өрөмдлөг (тэсэлгээ, хайгуулын өрөмдлөг) Хүнд даацын тоног төхөөрөмж ашигладаг үйл ажиллагаа. Тухайлбал овоолох, түрэх, тэгшлэх.г.м Материал тээвэрлэх 	Ил уурхай Ил уурхай Ил уурхай Ил уурхай	Дуу шуугиан/Чичиргээ Дуу шуугиан Дуу шуугиан Дуу шуугиан
2	Хайрганы карьерийн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Хүнд даацын тоног төхөөрөмж ашигладаг үйл ажиллагаа (НМЕ). Тухайлбал овоолох, түрэх г.м Материал тээвэрлэх 	Хог хаягдлын овоолго Хог хаягдлын овоолго	Дуу шуугиан Дуу шуугиан
3	Хүдэр баяжуулах тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Анхдагч бутлуурын үйл ажиллагаа – Үүнд овоолох, бутлах, нягтлуулах Туузан дамжуулагчаар тээвэрлэх Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа – овоолох, бутлах, ачих Материал тээвэрлэх 	Үндсэн бутлуур Туузан дамжуулагч Баяжуулах үйлдвэр Баяжуулах үйлдвэр	Дуу шуугиан Чичиргээ Дуу шуугиан Дуу шуугиан Дуу шуугиан
4	Хүнд даацын тоног төхөөрөмж ашигладаг хаягдал хадгалах байгууламжийн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Хүнд даацын тоног төхөөрөмж ашигладаг хаягдал хадгалах байгууламжийн үйл ажиллагаа 	Хаягдал хадгалах байгууламж	Дуу шуугиан
5	Хог хаягдлын менежментийн үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Хог хаягдал шатаах 	Хог шатаах зуух	Дуу шуугиан
6	Төслийн талбай дахь тээврийн хэрэгслийн ашиглалт <ul style="list-style-type: none"> Хөнгөн, хүнд даацын машиныг төслийн лицензит талбайд ажиллуулах 	Төслийн лицензит талбай	Дуу шуугиан
7	Дуу шуугиан гаргах бусад үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Зөөврийн үүсгүүрээр эрчим хүч үйлдвэрлэх Хоолны газрын агааржуулагч, хөргөгч 	Төслийн лицензит талбай Манлай кэмп	Дуу шуугиан Дуу шуугиан
B	Уурхайн лицензит талбайгаас гадна		

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө			
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01		Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0
1	Нисэх буудлын үйл ажиллагаа <ul style="list-style-type: none"> Нислэг Шувууны чиг өөрчлөгч Зорчигч тээвэр Эрчим хүч үйлдвэрлэх 	Нисэх буудал Нисэх буудал ОТ-Нисэх буудлын зам Нисэх буудал	Дуу шуугиан Дуу шуугиан Дуу шуугиан
2	Төрөл бүрийн материал тээвэрлэх <ul style="list-style-type: none"> Гашуун сухайт руу баяжмал тээвэрлэх Ачааны машин, цистернээр Гашуун сухайт болон МУ-ын бусад газраас материал импортлох 	ОТ-ГШ зам ОТ-ГШ зам Бусад зам - ОТ зам Ханбогд-ОТ зам	Дуу шуугиан
3	Гүний Хоолойн газрын доорхи усны нөөцийн ашиглалт <ul style="list-style-type: none"> Усны шахуургын эрчим хүчийг үйлдвэрлэх Шахуургаар шахах 	Гүний хоолой	Дуу шуугиан
4	Ханбогд сумаас ажилчдыг автобусаар тээвэрлэх	Ханбогд - ОТ зам	Дуу шуугиан

5.2 Хэрэгжилт

Дуу шуугианы түвшний удирдлагын арга хэмжээг Хүснэг 3-т тодорхойлогдсон Удирдлагын гол хяналтын шаардлагуудад тусгагдсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

Оюу толгойн өдөр тутмын Дуу шуугиан, чичиргээний Удирдлагын үйл ажиллагааны илүү нарийвчилсан мэдээлэл бүхий журмууд энэ Удирдлагын төлөвлөгөөг баяжуулдаг. Үүнд:

- Тэсэлгээний аюулгүй үйл ажиллагааны гарын авлагатай холбоотойгоор Тэсэлгээний стандарт ажлын журам болон
- Дуу шуугианний мониторинг болон холбогдохдуу шуугианний удирдлагын арга хэмжээнүүдийн арга зүй, байршил болон давтамжтай холбоотойгоор Дуу шуугианний мониторинг болон хяналтын журам (ОТ-10-Е6-PRC-0001) орно.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

Дуу шуугиан, чичиргээнээс үүдэн гарах асуудлуудаас сэргийлэх, бууруулахтай холбоотой хяналтуудыг доор байгаа Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4 Удирдлагын гол хяналтууд

ID	Хэрэгжилт/ Үйл ажиллагаа	Хяналтын ажлын тодорхойлолт	Хариуцах талууд	Баталгаажуулах аргачлалууд
NV01	Тэсэлгээний үйл ажиллагаа	<p>Тэсэлгээний ажлын төлөвлөлт, үйл ажиллагаа нь Тэсэлгээний стандарт ажлын журмын дагуу хийгдэнэ.</p> <p>Мөн Стандарт ажлын журмаас гадна Оюу толгой нь:</p> <ul style="list-style-type: none"> • Шаардлагатай үед тэсэлгээг хянан шинжилж, тэсэлгээний төлөвлөлтийг дахин хянадаг. • Тэсэлгээний зөв үзүүлэлт хүлээн авсан эсэхийг нягтлана. Тэсэлгээний үзүүлэлт гэдэг нь тэсэлгээний нэгж агуулгад хийгдэх нийт ажлын хэмжээг хэлдэг өөрөөр хэлбэл тонн/кг. • Хяналтын тэсэлгээ хийж, шалгана. • Шаардлагата үед тэсэлгээний цэнэгийн баганыг тус тусдаа салангид цэнэгүүдэд хуваана. • Тэсэлгээний төлөвлөгөөг гаргаж, хамгийн сайн тоног төхөөрөмж ашиглана. Шаардлагатай үед нөлөлөлт өртөх орон нутгийн иргэдэд тайлбар хийнэ. • Шаардлагатай үед цаг агаарын нөхцлөөс хамаарч тэсэлгээг хойшлуулж болно (салхи, температурын үзүүлэлт). <p><i>Тайлбар:</i> БОННБний судалгаанд үндэслэн дуу шуугиан, чичиргээний нөлөөлөлд хэт өртөгчид байхгүй гэж тодорхойлсон.</p>	<ul style="list-style-type: none"> • Ил уурхайн хэлтэс 	<ul style="list-style-type: none"> • Тэсэлгээний ажлын журманд хийх аудит • Сонгон авсан тэсэлгээний ажлын үеэрх чичиргээний мониторинг
NV02	Уурхайн талбай дахь дуу шуугианний	<p>Үйлдвэр, тоног төхөөрөмжийн ажиллагаанаас үүдэн уурхайн талбайд үүсч буй дуу шуугианний түвшинг Дуу шуугианний мониторинг, хяналтын журмын (ОТ-10-Е6-0001) хүрээнд хийгдэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> • ЭМААБОАБОН-н хэлтэс • Үйл ажиллагааны хэлтсүүд 	<ul style="list-style-type: none"> • Дотоод аудит • Дуу шуугианний талаарх бүртгэгдсэн

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо:
2013.09.01

Бичиг баримтын дугаар:
OT-10-E00-PLN-0001-M

Хувилбар:
2.0

ID	Хэрэгжилт/ Үйл ажиллагаа	Хяналтын ажлын тодорхойлолт	Хариуцах талууд	Баталгаажуулах аргачлалууд
	хяналт		<ul style="list-style-type: none"> Гэрээт гүйцэтгэгчид 	гомдлууд
NV03	Тээврийн хэрэгсэл жолоодох	Замын хөдөлгөөний дуу шуугианний түвшинг Тээвэрлэлтийн удирдлагын төлөвлөгөөний дагуу хянах бөгөөд уурхайн талбайд болон талбайгаас гадна тогтоосон хурдны хязгаарыг тогтоосон хязгаарт хянана.	<ul style="list-style-type: none"> ЭМААБОАБОН-н хэлтэс Дэд бүтцийн хэлтэс Ашиглалтын хэлтсүүд Тээврийн хэлтэс (Ашиглалтын болон гүний уурхайн) Гэрээтүүд 	<ul style="list-style-type: none"> Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний GPS ашиглан хянах
NV04	Амьтан, ургамлыг хамгаалах	Зэрлэг амьтанд үзүүлж болзошгүй тээврийн хөдөлгөөн болондуу шуугиан их үүсгэдэг тоног төхөөрөмжнөөс үүсэх сөрөг нөлөөллийг багасгах удирдлагын арга хэмжээ (Төслийн стандартад заасан хэмжээнээс илүү өндөр дуу шуугиан үүсгэх магадлалтай).	<ul style="list-style-type: none"> Ашиглалтын хэлтсүүд Байгаль орчны хэлтэс 	<ul style="list-style-type: none"> Аудит

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0

6. ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ

6.1 Удирдлагын төлөвлөгөөний хяналт болон өөрчлөлт

Энэ удирдлагын төлөвлөгөөг хамгийн багадаа хоёр жил тутамд болон үйл ажиллагаа, байгаль орчны нөхцлөөс хамааран илүү бага давтамжтайгаар хянан шалгаж байна.

Энэ Удирдлагын төлөвлөгөөнд орсон аливаа өөрчлөлт буюу шинэчлэгдсэн хувилбар нь Оюу толгойн нийт ажилчдын хүртээл болохын хүрээнд Оюу толгойн портал сайтад тавигдаж байна.

Тус удирдлагын төлөвлөгөөг хянан үзэх, өөрчлөх нь Оюутолгойн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, орон нутгийн ерөнхий менежерийн хариуцах үүрэг юм.

7. МОНИТОРИНГ

7.1 Хяналт шинжилгээний шаардлагуудын тойм

Төслийн стандартуудыг (Бүлэг 4: Төслийн стандартуудыг үзнэ үү) даган мөрдөж буйг үнэлэх зорилго бүхий үйл ажиллагааны үе шатанд хэрэгжүүлэх мониторингийн арга хэмжээний талаар энэхүү бүлэгт дурдсан.

Мониторингийн үйл ажиллагааны үеэр стандартыг дагаж мөрдөөгүй зөрчлүүд илэрсэн тохиолдолд тухайн зөрчлийг магадлан шинжилж, засч залруулах хариу арга хэмжээг тодорхойлно. (ОТ ЭМААБОАБОН-МС-ийн 14-р элемент, Үл нийцэл, осол зөрчил, арга хэмжээний Удирдлагаийг үзнэ үү).

7.2 Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

Оюутолгой нь уурхайн лицензийн талбайн дотор болон гаднах дуу шуугианний удирдлагын гүйцэтгэлийг тогтмол үргэлжлүүлэн үнэлж байх болно. Дуу шуугиан, чичиргээний удирдлагаийг үнэлэхэд баримтлах ГҮҮ-ийг Хүснэгт 3-т үзүүлэв. Мониторингтэй холбоотой асуудлуудыг доор байгаа Хүснэгт 4-т дэлгэрэнгүй тусгасан.

Хүснэгт 5: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд– Дуу шуугиан, чичиргээ

ID	Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
NV-KPI 01	Дуу шуугиан, чичиргээ хэтэрсэн осол зөрчил	Дуу шуугиан, чичиргээтэй холбоотойгоор бүртгэгдсэн зөрчлүүдийн тоог бууруулж, үргэлжлүүлэн сайжруулах арга хэмжээ авна.	Жилд тайлагнасан дуу шуугиан, чичиргээтэй холбоотой зөрчлийн тоо
NV-KPI 02	Дуу шуугиан, чичиргээний стандартыг дагаж мөрдөөгүй зөрчлүүд	Зорилт: Жилд 0 удаа. Босго: Жилд 5 удаа.	Байгаль, цаг агаарын нөхцлөөс үл хамааран төслийн дуу шуугиан, чичиргээний стандартыг дагаж мөрдөөгүй зөрчлийн тоо.
NV-KPI 03	Дуу шуугиантэй холбоотой нутгийн иргэдээс гаргасан	Зорилт: Жилд 0 удаа. Босго: Жилд 5 удаа.	Жилд гарсан Дуу шуугиантэй холбоотойгоор

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0
--	--	------------------

ID	Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд	гол	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
	гомдлын тоо.			нутгийн иргэдээс гаргах гомдлын тоо (Гомдол барагдуулах удирдлагын системд бүртгэгдсэнээр).

7.2.1 Мониторингийн гол үйл ажиллагаанууд

Төслийн стандартуудыг (Бүлэг 4.6-г харна уу) даган мөрдөж буйг нягтлах зорилго бүхий үйл ажиллагааны үе шатанд хэрэгжүүлэх мониторингийн арга хэмжээнүүдийг доорх 5-р хүснэгтэнд үзүүлэв. Мониторингийн үр дүнгээр Төслийн стандартыг хэтэрсэн зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчлийг магадлан шинжилж, засч залруулах хариу арга хэмжээг тодорхойлно. (БОНМТ-ний ОТ-10-PLN-0003 Баримт бичиг, тэдгээрийн нарийвчлал хэсгийг харна уу).

Төсөл нь 4.6-р бүлэгт тодорхойлсон холбогдох Төслийн стандартуудыг хэрэгжүүлж байгаа эсэхийг нягтлах зорилгоор жилийн Байгаль орчныг хамгааларх төлөвлөгөө, орчны мониторингийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлдэг. Нэмэлт мониторингийн шаардлагуудыг доор нарийвчлан оруулав.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-ПЛН-0001-М	Хувилбар: 2.0

Хүснэгт 6 Мониторингийн арга хэмжээ– Дуу шуугиан, чичиргээ

ID	Сэдэв	Үзүүлэлтүүд	Аргачлалууд	Хугацаа	Байршил
NVM1	Дуу шуугианы түвшин	Leq dB(A)- дицебалл	Тохиргоотой дуу шуугиан хэмжигч B&K Mediator 2238.	Улирал тутам	Янз бүрийн байршилд, үүнд мониторингийн суурь станцууд, нисэх буудал, Манлай, Оюут зэрэг уурхайн ажилчдын суурин, ОТ-ХБ зам ба ОТ-ГС замын төгсгөлийн хэсэг
NVM2	Дуу шуугианний хамрах хүрээ	Дуу шуугианы хамрах хүрээний шинжилгээ	Дуу шуугианы хамрах хүрээ хэмжигч– Мэргэшсэн зөвлөх гүйцэтгэх	Жил тутам , өдөр болон шөнийн үзүүлэлтээр	Янз бүрийн байршилд, үүнд уурхайн талбайн болон талбайн гаднах нөлөөлөлд өртөгчдийн байршлууд
NVM3	Тэсэлгээний хөрсний чичиргээ	Nm болон чичиргээний мэдээ бүртгэл	Чичиргээний мэдээ бүртгэл – Мэргэшсэн зөвлөх гүйцэтгэх	3 жил тутам, тэсэлгээний үеэр	Янз бүрийн байршилд, үүнд уурхайн талбайд болон талбайн гаднах нөлөөлөлд өртөгчдийн байршлууд
NVM4	Дуу шуугиан, чичиргээ Ажлын байрны үзлэг шалгалт	ҮХ	Тогтмол үзлэг шалгалтыг тухайн хэсгийн ахлагч болон ЭМААБОАБОН-ийн асуудал хариуцсан ажилтнууд хийж гүйцэтгэх.	Өдөр тутам	Бүх гол ажлын байрнуудад
NVM5	Дуу шуугианы төвшин	Leq dB(A)	Cirrus MK427 Дуу шуугианы сенсор	Байнгын	Агаарын чанарын суурин сүлжээ станцууд

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх
огноо:
2013.09.01

Бичиг баримтын дугаар:
ОТ-10-ЕОО-ПЛН-0001-М

Хувилбар:
2.0

8. СУРГАЛТ**8.1 Тойм**

Шаардлагатай бүх сургалтыг ерөнхий чиг баримжаа олгох Танилцуулах зааварчилгаа (ерөнхий мэдлэг олгох) болон ажлын байрнаас хамаарах сургалтын хэлбэрээр зохион байгуулагдана.

8.2 Танилцуулах зааварчилгаа

Оюутолгой төслийн бүх ажилчдыг чиг баримжаа олгох Танилцуулах зааварчилгаа, уурхайн зааварчилгаа болон ЭМААБОАБОН-ийн талаарх мэдлэг олгох сургалтанд заавал хамруулсан байна.

8.3 Ажлын байран дахь сургалт

Оюу Толгойд ажиллах буй бүх ажилчид нь ажил эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тогтмол сууна. Энэ сургалтаар шаардлагатай үед дуу шуугиан, чичиргээний удирдлагын талаар мэдээлэл өгнө.

8.4 Бусад сургалтын хэрэгцээ шаардлага

Их хэмжээний дуу шуугиан үүсгэх ажил хийж буй Оюутолгойн бүх ажилчдад *Хүснэгт 3*-т үзүүлсэн дуу шуугианг бууруулах тусгайлсан арга хэмжээний талаарх сургалтад хамрагдана.

Тэсэлгээний ажил гүйцэтгэх операторуудад чичиргээг бууруулах талаар тусгайлсан сургалтыг явуулна. Нөлөөлөлд өртөж буй иргэд амьдардаг бүсэд машин тоног төхөөрөмж, хүнд механизм ажиллуулж буй операторуудад дуу шуугианний хяналт, дуу шуугианг бууруулах боломжтой арга хэмжээ, тэдгээрийн ач холбогдлын тухай сургалтыг явуулна.

Бүх ажилчдын хамрагдах чиг баримжаа олгох Танилцуулах сургалтанд байгаль орчны удирдлагын ерөнхий асуудлуудыг заавал багтаасан байна.

9. АУДИТ БОЛОН ТАЙЛАН**9.1 Дотоод аудит**

Тогтмол үзлэг шалгалтыг тухайн үйл ажиллагааны салбарын Ахлах мэргэжилтэн/Ахлах ажилтан мөн ЭМААБОАБОН—н ажилчид ЭМААБОАБОН-ийн чиглэлээр өргөн хүрээнд гүйцэтгэнэ.

Эдгээр хяналт шалгалтаар илэрсэн аливаа зөрчлийг зөрчлийн удирдлагын системд бүртгэж оруулна (14-р элемент).

Хуулийн нийцтэй байдал нь элемент 16-Гүйцэтгэлийн үнэлгээ, аудитийн дагуу Дотоодын жилийн аудитын хөтөлбөрийн дагуу хянадаг. Энэ нь ЭМААБОАБОН-ийн Удирдлагын Системийн шаардлагад хир нийцэж байгааг үнэлэхийн тулд гүйцэтгэгддэг (БОННБҮ болон Удирдлагын төлөвлөгөөг оруулаад).

Эдгээр хяналт шалгалтаар илэрсэн аливаа хуулийн нийцэмжгүй байдал болон зөрчил нь Байгаль орчны БОНМТ-ний баримтанд тодорхойлогдсон Оюу толгойн ЭМААБОАБОН-ийн Удирдлагын системийн шаардлагын дагуу бүртгэгдэнэ.

Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01	Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

9.2 Гадаад аудит

Рио Тинто корпорацийн ЭМААБО бизнесийн нийцэмжтэй байдлын аудитын хөтөлбөр болон төслийн зээлдэгчид нь энэ төлөвлөгөөний нийцэмжтэй байдалд тодорхой хугацааны давтамжтайгаар үнэлгээ хийж байна.

9.3 Гүйцэтгэлийн тайлан

Аудит, үзлэг шалгалт, осол зөрчлийн бүртгэл нь Элемент-8 Баримт бичиг ба баримт бичгийн хяналт болон Элемент-15 Тоо мэдээллийн бүртгэлийн Удирдлагын дагуу зохицуулагдана.

Рио Тинто Бизнес солушин программ нь дотоод болон гадаад аудитаар илэрсэн үл нийцтэй байдал болон холбогдох арга хэмжээ мөн Зөрчил болон холбогдох судалгаа, арга хэмжээг бүртгэдэг.

10. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ

Файлын нэр	ОТ-10-Е00-PLN-0001-М- Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө
Эхийг зохиогч	Газар ба Мониторингийн баг
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	#

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Дунд	2013.09.01	Газар ба хяналт шинжилгээний баг	2 жил бүр	2019.11.20

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	Газар ба Мониторингийн баг	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баримт бичгийн дугаарлалтыг засч, баримт бичгийг хянав.
1.2	2015.07.10	Л.Цэцэгсүрэн Дэнис Х Махони Ди	Кэрри Эдвардс, ЭМААБОАБОН хэлтэсийн Ерөнхий менежер	Өөрчлөлт оруулсан тэмдэглэл 2015-10 Тогтмол хяналт – дараах өөрчлөлт шинэчлэл хийв. үүнд Рио Тинтогийн өөрчлөлт оруулсан стандартад нийцүүлсэн, Шаардлагатай албан тушаал, үүрэг хариуцлагыг нэмсэн, Дуу шуугиан, чичиргээнд нөлөөлж байгаа нэмэлт гол хүчин зүйлсийг нэмсэн, жагсаалтыг хүснэгтэнд оруулж холбогдох үйл ажиллагааг дэлгэрэнгүй тайлбарласан.



Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр эхлэх огноо: 2013.09.01		Бичиг баримтын дугаар: ОТ-10-Е00-PLN-0001-М		Хувилбар: 2.0
2.0	2017.11.20	Лувсангийн Цэцэгсүрэн	Нарангийн Эрдэнэбаяр, Байгаль орчин ба Биологийн олон янз байдал хариуцсан менежер	Хугацаат хяналт: Удирдлагын бусад төлөвлөгөөтэй давхцах нь хэсэгт: Гүйцэтгэгчийн удирдах тогтолцоо (ОТ-07-PLN-0001-Е)-г нэмэв. Үүрэг хариуцлага хэсэгт Гэрээт байгууллагуудын хамтын ажиллагааны хэлтсийг хүснэгт 1-д нэмэв. Хүснэгт 3 дахь холбогдох хэлтэс болон баталгаажуулалтын талаар мэдээлэл нэмэв. Дуу шуугианы төвшний хяналт шинжилгээ (NVM1) давтамжийг улирал тутам, доргио чичиргээний (NVM3) давтамжийг 3 жил тутамд болгож өөрчлөв. Хяналт шинжилгээний байршлын хүснэгт болон зургийг шинэчлэв. Хүснэгт 5-д Агаарын чанарын сүлжээ станцын байнгын дуу шуугианы хэмжилтийн талаар (NVM5) мэдээлэл нэмэв.